# Номыг буруу уншвал мэдрэлийн системийн хэвийн vйл ажиллагааг алдагдуулдаг

Бичсэн Ariya
2017 оны 9-р сарын 21, Пvрэв гариг, 12:50 - Сvvлд шинэчлэгдсэн 2017 оны 9-р сарын 21, Пvрэв гариг, 12:53



## Муу уншлага

Муу унших нь зов уншсанаар гарах ашгийг бууруулах хорт нолоотэй юм. Уншлагыг хоёр талаас нь авч vзэж болно. Юу унших вэ? Яаж унших вэ? Аль ч талаас нь авч vзсэн ном унших нь хортой, хохиролтой байж болохыг vгvйсгэхгvй.

## Юу унших вэ?

Хvнд хэрэггvй, уншихад хор болох ном байдаг. Үvнээс гадна ном унших арга нь оороо хvний мах бодь болон сэтгэл зvйд хор хvргэж болно. Номыг “залгих” зуршил нь толгой овтгодог. Мон цаашилбал мэдрэлийн системийн хэвийн vйл ажиллагааг алдагдуулдаг. Зvй бус уншлага нь заримдаа чадварын хэвийн хогжлийг сааруулахаас гадна тvvнийг балладаг. Жишээ нь: анхаарал товлорvvлэх чадвар, ой тогтоолтыг бууруулах гэх мэт. Мон сэтгэх чадвар, хvсэл зоригийг сулруулдаг.

***Зvй бус уншлага нь хvсээд баймааргvй хоёр төрлийн хvнийг бий болгодог. Тодруулбал “хоосон цэцэрхэгч” ба “толгойдоо холион бантантай хvн”.***

**“Хоосон цэцэрхэгч”** гэдэг нь онч мэргэн vгс хэрэглэх дуртай боловч “дотор хvн” нь vvнтэйгээ нийцдэггvй хvн юм. Бодол санаа, мэдрэхvй болон тэдгээртэй холбоотой зvйлvvд нь vнэн хэрэгтээ тvvний хувьд айхтар ялгаа байхгvй. Тvvний амьдрал, хийж буй алхмууд нь эсрэг тэсрэг бодол санаа ба мэдрэхvйгээр ихэнхдээ тодорхойлогддог.

**‘Толгойдоо холион бантантай хvн”** бол энд тэндээс хагас дутуу мэдлэгийг зулгаасан хvн юм гэж ойлгож болно. Эдгээр мэдлэгvvд нь хоорондоо ямар ч холбоогvй байхаас гадна системгvй, муу ойлгогдсон, боловсруулагдаагvй байдаг. Ийм хvнд мэдээж ертонцийг vзэх тууштай vзэл байхгvй, ийм хvнтэй юм ярих их зовлонтой. Ярьж буй зvйлийн утга санаа нь vргэлж vсчиж байдаг. “Толгой дахь холион бантан” нь зvй бус уншлагын vр дvн, олон номыг хуурмаг уншсаны гай юм.

Эх сурвалж: news.zone.mn